



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 19 өдөр

Дугаар Д/142

Хэрлэн сум

Автомашины засварын зардалд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, 32.1.10 дахь заалт, аймгийн онцгой комиссын даргын 2024 оны 8 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Аймгийн зудын гамшигтай тэмцэх, хариу арга хэмжээний хүрээнд Галшар сумын иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд дайчилгаагаар ажилласан автомашины засварын зардалд шаардагдах 7.315.000 (долоон сая гурван зуун арван таван мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Зудын гамшгийн үед дайчилгаагаар ажиллах автомашины бэлэн байдлыг хангах, үүрэг гүйцэтгэлтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, хурандаа (Ж.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

4. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны
03 дугаар сарын 19-ны
А.142 дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Урд редуктор цоожлогчтой	1 ком	3.850.000	3.850.000
2	R талын тормозны базагч	1 ширхэг	480.000	480.000
3	Чагтан гол /хойд/	2 ширхэг	120.000	240.000
4	Чагтан гол /урд/	2 ширхэг	85.000	170.000
5	Нум	2 ком	1.250.000	2.500.000
6	Редукторын тос 80/90	3 литр	25.000	75.000
Нийт				7.315.000